



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот  
2025 он

## АГУУЛГА

I. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО .....	2
II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА .....	5
III. ӨРХИЙН ЗЭЭЛ.....	10



Нэг өрхөд сард ногдох дундаж үзүүлэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд хамрагдсан 1,987 өрхийн өгөгдөлд үндэслэн сард шилжүүлэн нийт өрхөд тархаан тооцлоо.

Нэг өрхөд ногдох сарын дундаж орлого, зарлагыг тооцохдоо цалин хөлсний орлого болон хүнсний хэрэглээний зарлагаас бусад төрлийн орлого, зарлагын сүүлийн 12 сарын өгөгдлийг сард шилжүүлэн тооцсон болно.

**Өрхийн орлого:** Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнес, хөрөнгө оруулалт, тэтгэвэр, тэтгэмж, халамж болон бусад эх үүсвэрээс олж буй бүх төрлийн мөнгөн болон мөнгөн бус орлогыг хэлнэ. Өрхийн нийт орлогыг тооцохдоо өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

**Өрхийн зарлага:** Өрхийн хэрэглээнд зориулагдан зарцуулсан бүх бараа, үйлчилгээний мөнгөн болон мөнгөн бус зардлыг хэлнэ. Үүнд: хүнс, хувцас, орон сууц, эрүүл мэнд, боловсрол, тээвэр, холбоо, ахуйн хэрэглээний бараа, үйлчилгээний төлбөр, зээлийн төлбөр зэрэг хэрэглээний зардлууд ордог. Өрхийн нийт зарлагыг тооцохдоо өрхийн мөнгөн зарлага, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Өрхийн мөнгөн зарлага нь хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусдад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлагаас бүрдэнэ.

## I. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт орлого 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 99.2 (5.8%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 47.3 (2.7%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэг өрхийн сарын дундаж бодит мөнгөн орлого 1.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 90.3 (5.6%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 42.3 (2.6%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Бодит орлогын өсөлтийг төрлөөр задалж үзвэл, өмнөх оны мөн үеэс цалин хөлсний орлого 52.5 (5.7%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 17.0 (4.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бодит нийт орлого 5.8 хувиар нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

### ХҮСНЭГТ 1. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ БОДИТ ОРЛОГО, 2020 оны зэрэгцүүлэх үнээр

Орлогын төрөл	2022	2023	2024		2025	2025 I-III/2024 I-III	
	I-III	I-III	I-III	X-XII	I-III	дүн	хувь
	мянган төгрөг						
<b>Нийт орлого</b>	<b>1 516.7</b>	<b>1 455.3</b>	<b>1 710.4</b>	<b>1 762.2</b>	<b>1 809.5</b>	<b>99.2</b>	<b>5.8</b>
<b>1. Мөнгөн орлого</b>	<b>1 398.2</b>	<b>1 357.2</b>	<b>1 610.7</b>	<b>1 658.7</b>	<b>1 701.0</b>	<b>90.3</b>	<b>5.6</b>
Цалин хөлс	666.3	720.7	924.1	949.0	976.6	52.5	5.7
Тэтгэвэр, тэтгэмж	413.8	331.3	357.3	382.8	374.4	17.0	4.8
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	115.8	144.7	123.8	127.6	128.6	4.8	3.9
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	71.0	67.5	93.1	79.4	95.6	2.5	2.7
Бусад орлого	131.4	93.0	112.4	120.0	125.9	13.5	12.0
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>50.4</b>	<b>39.8</b>	<b>39.6</b>	<b>41.4</b>	<b>42.6</b>	<b>3.0</b>	<b>7.7</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>68.0</b>	<b>58.3</b>	<b>60.1</b>	<b>62.1</b>	<b>65.9</b>	<b>5.8</b>	<b>9.6</b>

Нэг өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 2.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 394.3 (16.3%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 175.9 (6.7%) мянган төгрөгөөр, мөнгөн орлого 2.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 366.5 (16.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 162.2 (6.5%) мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


Мөнгөн орлогын бүтцийг авч үзвэл, мөнгөн орлогын 57.4 (1.5 сая) хувийг цалин хөлсний орлого, 22.0 (582.9 мянга) хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 7.6 (200.2 мянга) хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, 5.6 (148.8 мянга) хувийг хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 7.4 (196.0 мянга) хувийг бусад орлого бүрдүүлж байна.

## ХҮСНЭГТ 2. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, оны үнээр

Орлогын төрөл	2022	2023	2024		2025	2025 I-III/2024 I-III	
	I-III	I-III	I-III	X-XII	I-III	дүн	хувь
	мянган төгрөг						
<b>Нийт орлого</b>	<b>1 785.8</b>	<b>1 923.5</b>	<b>2 423.3</b>	<b>2 641.7</b>	<b>2 817.6</b>	<b>394.3</b>	<b>16.3</b>
<b>1. Мөнгөн орлого</b>	<b>1 646.4</b>	<b>1 793.7</b>	<b>2 282.1</b>	<b>2 486.5</b>	<b>2 648.7</b>	<b>366.5</b>	<b>16.1</b>
Цалин хөлс	784.6	952.5	1 309.4	1 422.6	1 520.7	211.3	16.1
Тэтгэвэр, тэтгэмж	487.2	437.8	506.3	573.9	582.9	76.6	15.1
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	136.3	191.3	175.4	191.2	200.2	24.8	14.2
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	83.6	89.2	131.9	119.0	148.8	17.0	12.9
Бусад орлого	154.7	122.9	159.2	179.8	196.0	36.8	23.1
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>59.4</b>	<b>52.7</b>	<b>56.1</b>	<b>62.1</b>	<b>66.4</b>	<b>10.3</b>	<b>18.4</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>80.1</b>	<b>77.1</b>	<b>85.1</b>	<b>93.1</b>	<b>102.6</b>	<b>17.4</b>	<b>20.5</b>

### ЗУРАГ 1.

#### НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, бусад орлогын эзлэх хувь 0.4 нэгж хувиар нэмэгдэж, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 0.2 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 0.1 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 0.2 нэгж хувиар буурсан байна.

Өрхийн сарын дундаж орлогыг хот, хөдөөгөөр нь авч үзвэл, хотын өрхүүдийн сарын дундаж нийт орлого оны үнээр 3.1 сая төгрөг, хөдөөгийнх 2.3 сая төгрөг байна. Хотын өрхүүдийн сарын дундаж нийт орлого хөдөөгийн өрхүүдээс 735.3 (31.7%) мянган төгрөгөөр их байна.

Бодит орлогыг авч үзвэл, 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт орлого хотод 2.0 сая төгрөг, хөдөөд 1.5 сая төгрөг болж, хотын өрхүүдийн сарын дундаж бодит нийт орлого хөдөөгийн өрхүүдээс 472.2 мянган төгрөгөөр их байна.

Бүсээр харвал, өрхийн сарын дундаж нийт орлого оны үнээр 2.1-2.6 сая төгрөг байгаа бол бодит нийт орлого 1.3-1.6 сая төгрөг байна.

## ЗУРАГ 2.

### НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар, хот, хөдөө, бүс, суурьшлаар, мянган төгрөгөөр



Өрхүүдийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзэхэд 2025 оны 1 дүгээр улиралд 700.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 82.4 (8.2%) мянга, 700.0-1600.0 мянган төгрөгийн орлоготой өрх 239.2 (23.8%) мянга, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой өрх 330.6 (32.9%) мянга, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 352.7 (35.1%) мянга байна.

Мөнгөн орлогын бүлэглэлт тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, 700.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 46.6 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 8.3 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрх 20.3 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрх 17.1 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрх 0.6 мянгаар буурсан бол, 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрх 7.6 мянгаар, 3.0-4.0 сая төгрөгийн орлоготой өрх 32.7 мянгаар, 4.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 64.9 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

## ХҮСНЭГТ 3.

### МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн орлогын бүлэг	2024 I-III		2024 X-XII		2025 I-III	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
700 000 төгрөг хүртэл	129.0	13.0	109.5	10.9	82.4	8.2
700 001 – 900 000	60.6	6.1	54.2	5.4	52.3	5.2
900 001 – 1 100 000	66.5	6.7	52.2	5.2	46.2	4.6
1 100 001 – 1 600 000	157.8	15.9	135.5	13.5	140.7	14.0
1 600 001 – 2 100 000	128.1	12.9	133.5	13.3	135.7	13.5
2 100 001 – 3 000 000	195.5	19.7	215.8	21.5	194.9	19.4
3 000 001 – 4 000 000	125.1	12.6	139.5	13.9	157.8	15.7
4 000 001 төгрөгөөс дээш	130.0	13.1	163.6	16.3	194.9	19.4

Улсын хэмжээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар сард 700.0 мянган төгрөг хүртэл орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 70.4 хувийг, 700.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 55.3 хувийг, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 50.9 хувийг тус тус тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа

бөгөөд өрхийн мөнгөн орлогын хэмжээ нэмэгдэхийн хэрээр тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь буурч байна. Нөгөөтэйгүүр, өрхийн мөнгөн орлогын хэмжээ нэмэгдэхийн хэрээр цалин хөлсний орлогын эзлэх хувь хэмжээ өсөж байна. Тухайлбал, сард 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 42.4 хувийг, 2.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхийн дундаж мөнгөн орлогын 65.0 хувийг цалин хөлсний орлого бүрдүүлж байна.

#### ХҮСНЭГТ 4. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн орлогын бүлэг	Дундаж мөнгөн орлого	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	ХАА-н үйлдвэрлэлийн орлого	ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого
700 000 төгрөг хүртэл	463 964	33 578	325 719	74 544	10 738	19 385
700 001 – 1 100 000	915 163	194 096	479 902	138 048	50 472	52 645
2024 I-III 1 100 001 – 1 600 000	1 335 978	457 987	612 570	130 484	64 877	70 060
1 600 001 – 2 100 000	1 847 771	901 442	576 318	158 589	122 240	89 182
2 100 001 төгрөгөөс дээш	3 636 091	2 397 712	508 232	235 003	215 307	279 837
700 000 төгрөг хүртэл	489 987	31 917	344 770	57 926	10 246	45 128
700 001 – 1 100 000	894 791	123 680	494 727	154 605	38 430	83 349
2025 I-III 1 100 001 – 1 600 000	1 346 068	327 500	685 324	179 738	83 454	70 052
1 600 001 – 2 100 000	1 849 160	783 187	718 086	147 834	95 648	104 405
2 100 001 төгрөгөөс дээш	3 822 513	2 485 908	574 821	248 153	219 579	294 052

## II. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт зарлага 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 90.2 (5.2%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 19.0 (1.0%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн нэг өрхийн сарын дундаж бодит мөнгөн зарлага 1.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 81.3 (4.9%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 14.0 (0.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Бодит зарлагын өсөлтийг төрлөөр задалж үзвэл, өмнөх оны мөн үеэс хүнсний бус бараа, үйлчилгээний зардал дунджаар 66.1 (6.0%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бодит нийт зарлага 5.2 хувиар нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

## ХҮСНЭГТ 5. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ БОДИТ ЗАРЛАГА, 2020 оны зэрэгцүүлэх үнээр

Зарлагын төрөл	2022	2023	2024		2025	2025 I-III/2024 I-III	
	I-III	I-III	I-III	X-XII	I-III	дүн	хувь
	мянган төгрөг						
<b>Нийт зарлага</b>	<b>1 474.6</b>	<b>1 471.6</b>	<b>1 744.1</b>	<b>1 815.3</b>	<b>1 834.3</b>	<b>90.2</b>	<b>5.2</b>
<b>1. Мөнгөн зарлага</b>	<b>1 356.2</b>	<b>1 373.4</b>	<b>1 644.4</b>	<b>1 711.8</b>	<b>1 725.8</b>	<b>81.3</b>	<b>4.9</b>
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	304.8	297.1	334.4	305.3	337.9	3.5	1.0
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	901.2	894.9	1 098.5	1 176.0	1 164.7	66.1	6.0
Бусад зарлага	125.2	149.9	179.2	192.4	189.9	10.6	5.9
Бусдад өгсөн бэлэг, тусламж	24.9	31.5	32.3	38.0	33.3	1.1	3.4
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>50.4</b>	<b>39.8</b>	<b>39.6</b>	<b>41.4</b>	<b>42.6</b>	<b>3.0</b>	<b>7.7</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>68.0</b>	<b>58.3</b>	<b>60.1</b>	<b>62.1</b>	<b>65.9</b>	<b>5.8</b>	<b>9.6</b>

Нэг өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 2.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 385.0 (15.6%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 134.8 (5.0%) мянган төгрөгөөр, мөнгөн зарлага 2.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 357.3 (15.3%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 121.1 (4.7%) мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


Мөнгөн зарлагын бүтцийг авч үзвэл, мөнгөн зарлагын 67.5 (1.8 сая) хувийг хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага, 19.6 (526.1 мянга) хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага, 1.9 (51.9 мянга) хувийг бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлага, 11.0 (295.6 мянга) хувийг бусад зарлага эзэлж байна.

## ХҮСНЭГТ 6. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, оны үнээр

Зарлагын төрөл	2022	2023	2024		2025	2025 I-III/2024 I-III	
	I-III	I-III	I-III	X-XII	I-III	дүн	хувь
	мянган төгрөг						
<b>Нийт зарлага</b>	<b>1 736.3</b>	<b>1 944.9</b>	<b>2 471.1</b>	<b>2 721.3</b>	<b>2 856.1</b>	<b>385.0</b>	<b>15.6</b>
<b>1. Мөнгөн зарлага</b>	<b>1 596.8</b>	<b>1 815.2</b>	<b>2 329.9</b>	<b>2 566.1</b>	<b>2 687.2</b>	<b>357.3</b>	<b>15.3</b>
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	358.9	392.6	473.8	457.7	526.1	52.3	11.0
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	1 061.1	1 182.8	1 556.4	1 762.9	1 813.5	257.1	16.5
Бусад зарлага	147.5	198.1	254.0	288.5	295.6	41.6	16.4
Бусдад өгсөн бэлэг, тусламж	29.3	41.6	45.7	57.0	51.9	6.2	13.6
<b>2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>59.4</b>	<b>52.7</b>	<b>56.1</b>	<b>62.1</b>	<b>66.4</b>	<b>10.3</b>	<b>18.4</b>
<b>3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>80.1</b>	<b>77.1</b>	<b>85.1</b>	<b>93.1</b>	<b>102.6</b>	<b>17.4</b>	<b>20.5</b>

**ЗУРАГ 3.**

**НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар, улсын дунджаар**



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын эзлэх хувь 0.1 нэгж хувиар буурч, харин хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь 0.7 нэгж хувиар, бусад зарлагын эзлэх хувь 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Өрхийн сарын дундаж зарлагыг хот, хөдөөгөөр авч үзвэл, хотын өрхүүдийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 3.0 сая төгрөг, хөдөөгийнх 2.4 сая төгрөг байна. Хотын өрхүүдийн сарын дундаж нийт зарлага хөдөөгийн өрхүүдээс 601.0 (24.6%) мянган төгрөгөөр их байна.

Бодит зарлагыг авч үзвэл, 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр 2020 оны үнээр илэрхийлэгдсэн нэг өрхийн сарын дундаж бодит нийт зарлага хотод 2.0 сая төгрөг, хөдөөд 1.6 сая төгрөг болж, хотын өрхүүдийн сарын дундаж бодит нийт зарлага хөдөөгийн өрхүүдээс 386.0 мянган төгрөгөөр их байна.

Бүсээр харвал, нэг өрхийн сарын дундаж нийт зарлага оны үнээр 2.3-2.7 сая төгрөг байгаа бол 2020 оны үнээр илэрхийлэгдсэн бодит нийт зарлага 1.5-1.8 сая төгрөг байна.

**ЗУРАГ 4.**

**НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар, хот, хөдөө, бүс, суурьшлаар, мянган төгрөгөөр**



Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 31.1 (163.5 мянга) хувийг мах, махан бүтээгдэхүүн, 23.8 (125.1 мянга) хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 12.3 (64.7 мянга) хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 7.8 (40.9 мянга) хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал эзэлж байгаа нь нийт хүнсний хэрэглээний 75 хувийг бүрдүүлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний зарлагын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мах, махан бүтээгдэхүүний нийт хүнсний зарлагад эзлэх хувь 1.1 нэгж хувиар, жимс, самар 0.6 нэгж хувиар, хүнсний ногоо, булцуут, навчит ургамал 0.4 нэгж хувиар нэмэгдэж, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн 1.7 нэгж хувиар, төрөл бүрийн өөх, тос 0.5 нэгж хувиар, элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан 0.3 нэгж хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг 0.2 нэгж хувиар буурсан байна.

## ХҮСНЭГТ 7.

### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Хүнсний бүтээгдэхүүний гол нэр төрөл	2024 I-III	2024 X-XII	2025 I-III
Маж, махан бүтээгдэхүүн	141 975	135 467	163 536
Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн	120 710	123 262	125 059
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	59 394	50 609	64 672
Хүнсний ногоо, булцуут, навчит ургамал	34 784	32 778	40 887
Жимс, самар	15 943	17 925	21 030
Элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан	17 402	14 023	17 774
Цэвэр ус, ундаа, жимсний шүүс	14 088	13 457	17 381
Төрөл бүрийн өөх, тос	14 512	12 248	13 465
Цай, кофе	8 775	8 306	8 820

Мөн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 13.2 (240.1 мянга) хувийг тээврийн хэрэгслийн шатахуун, сэлбэг, засвар, үйлчилгээний зардал, 11.5 (208.7 мянга) хувийг бэлэн хувцас, гутал, 6.8 (123.1 мянга) хувийг харилцаа холбооны үйлчилгээний зардал, 6.6 (119.8 мянга) хувийг хувь хүнд хандсан бараа, үйлчилгээний зардал, 6.2 (112.1 мянга) хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал, 4.4 (79.9 мянга) хувийг боловсролын зардал эзэлж байна.

## ХҮСНЭГТ 8.

### ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Хүнсний бус бараа, үйлчилгээний гол нэр төрөл	2024 I-III	2024 X-XII	2025 I-III
Тээврийн хэрэгслийн шатахуун, сэлбэг, засвар	154 152	178 585	192 902
Бэлэн хувцас	123 195	147 241	135 085
Харилцаа холбооны үйлчилгээ	97 471	113 851	123 124
Хувь хүнд хандсан бараа, үйлчилгээ	96 144	111 060	119 793
Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ	90 680	113 462	112 076
Боловсрол	83 522	81 226	79 939
Гутал, хос	67 601	75 414	73 567
Сууцны төлбөр	58 461	58 295	70 614
Чөлөөт цаг болон соёлын үйлчилгээ	44 940	59 623	69 255
Тээврийн үйлчилгээ	34 080	46 470	47 228
Цахилгаан	33 199	38 133	43 436
Түлш	31 564	43 556	38 530

Өрхүүдийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзэхэд 2025 оны 1 дүгээр улиралд 700.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 40.2 (4.0%) мянга, 700.0-1600.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 231.1 (23.0%) мянга, 1.6-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 388.9 (38.7%) мянга, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 344.7 (34.3%) мянган өрх байна.

Мөнгөн зарлагын бүлэглэлт тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, 700.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 15.4 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 18.4 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 31.2 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрх 33.0 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрх 13.1 мянгаар буурсан бол, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 28.8 мянгаар, 3.0-4.0 сая төгрөгийн зарлагатай өрх 53.9 мянгаар, 4.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 40.7 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

## ХҮСНЭГТ 9. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн зарлагын бүлэг	2024 I-III		2024 X-XII		2025 I-III	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
700 000 төгрөг хүртэл	55.6	5.6	55.2	5.5	40.2	4.0
700 001 – 900 000	60.6	6.1	54.2	5.4	42.2	4.2
900 001 – 1 100 000	76.4	7.7	54.2	5.4	45.2	4.5
1 100 001 – 1 600 000	176.7	17.8	142.5	14.2	143.7	14.3
1 600 001 – 2 100 000	155.8	15.7	146.6	14.6	142.7	14.2
2 100 001 – 3 000 000	217.4	21.9	233.9	23.3	246.2	24.5
3 000 001 – 4 000 000	129.0	13.0	159.6	15.9	182.9	18.2
4 000 001 төгрөгөөс дээш	121.1	12.2	157.6	15.7	161.8	16.1

Улсын хэмжээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар сард 700.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 28.6 хувийг, 700.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 28.6 хувийг, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 25.1 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага тус тус эзэлж байгаа бол 2.1 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 18.3 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага, 70.2 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага эзэлж байна.


## ХҮСНЭГТ 10. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн зарлагын бүлэг		Дундаж мөнгөн зарлага	Хүнсний бүтээгдэхүүний зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	Бусад зарлага	Бусад өгсөн бэлэг, тусламж
2024 I-III	700 000 төгрөг хүртэл	502 413	147 541	238 258	109 468	7 146
	700 001 – 1 100 000	912 423	271 751	454 101	165 648	20 923
	1 100 001 – 1 600 000	1 360 148	359 828	761 045	217 948	21 327
	1 600 001 – 2 100 000	1 842 104	425 904	1 109 327	266 572	40 301
	2 100 001 төгрөгөөс дээш	3 491 546	630 927	2 485 613	306 452	68 554
2025 I-III	700 000 төгрөг хүртэл	509 183	145 806	244 019	110 743	8 615
	700 001 – 1 100 000	907 382	259 311	463 049	162 967	22 055
	1 100 001 – 1 600 000	1 363 964	341 750	764 900	231 290	26 024
	1 600 001 – 2 100 000	1 848 366	420 885	1 119 864	269 196	38 421
	2 100 001 төгрөгөөс дээш	3 620 026	661 278	2 540 359	349 587	68 802

### III. ӨРХИЙН ЗЭЭЛ

Судалгааны 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр нийт өрхийн 69.2 хувь буюу 695.8 мянган өрх зээлтэй амьдарч байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.9 нэгж хувиар нэмэгдсэн байна.


**ЗУРАГ 5. ЗЭЭЛТЭЙ ӨРХ (ХУВЬ), ЗЭЭЛИЙН ТӨРЛӨӨР**



Нийт зээлтэй өрхийг зээлийн төрлөөр нь авч үзэхэд 37.0 хувь (257.1 мянган өрх) цалингийн зээлтэй, 29.7 хувь (206.9 мянган өрх) хэрэглээний зээлтэй, 24.1 хувь (167.6 мянган өрх) тэтгэврийн зээлтэй, 14.0 хувь (97.3 мянган өрх) орон сууцны зээлтэй, 30.2 хувь (210.1 мянган өрх) бусад төрлийн зээлтэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулвал, тэтгэврийн зээлтэй өрх 3.5 нэгж хувиар, хэрэглээний зээлтэй өрх 4.4 нэгж хувиар нэмэгдэж, орон сууцны зээлтэй өрх 0.3 нэгж хувиар, бусад төрлийн зээлтэй өрх 1.6 нэгж хувиар буурсан байна.


**ЗУРАГ 6. СҮҮЛИЙН 12 САРЫН ХУГАЦААНД АВСАН ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, сая төгрөгөөр**



Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн дундаж хэмжээг харвал, зээлтэй нэг өрх дунджаар 18.7 сая төгрөгийн зээл авсан нь өмнөх оны мөн үеэс 4.4 (30.8%) сая төгрөгөөр нэмэгджээ. Орон сууцны зээлийн дундаж хэмжээ 120.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.1 (69.3%) сая төгрөгөөр, хэрэглээний зээлийн дундаж хэмжээ 5.4 (51.9%) сая төгрөгөөр, цалингийн зээлийн дундаж хэмжээ 2.2 (17.9%) сая төгрөгөөр, тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 1.3 (25.0%) сая төгрөгөөр, өрхийн бусад зээлийн дундаж хэмжээ 4.5 (35.4%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 7.

## ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН САРЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, мянган төгрөгөөр



Зээлтэй нэг өрх сард дунджаар 1.2 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд буцаан төлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 162.2 (15.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Зээлийн төрлөөр нь авч үзвэл, тэтгэврийн зээлтэй өрх сард дунджаар 706.3 мянган төгрөгийг, хэрэглээний зээлтэй өрх 844.6 мянган төгрөгийг, цалингийн зээлтэй өрх 881.2 мянган төгрөгийг, орон сууцны зээлтэй өрх 1.1 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулж байгаа нь өмнөх оны мөн үеэс 56.6-180.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол, өрх мөн бусад зээлэндээ сард дунджаар 1.2 сая төгрөг зарцуулж байгаа нь өмнөх оны мөн үеэс 75.3 (6.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН  
ӨРХӨД СУУРИЛСАН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС